



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2023/115/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Ц.Уртнасан

Утас: 70376994 Цахим хаяг: dalaivandarkhan@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ЗГ	Засгийн газар
ОУБ	Олон улсын байгууллага

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3.Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.1.Байгууллага түүний үйл ажиллагаа.....	13
3.2. Байгууллагын гадаад дотоод орчин.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..	14
3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
4.Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. Аудитын илрүүлэлт.....	20
5.1 Акт.....	20
5.2 Албан шаардлага.....	21
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	22



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЕРӨӨ СУМЫН БУГАНТ ТОСГОНЫ
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ П.ДАВААЖАРГАЛ ТАНАА

2023.02.25 № 107-2023/ИС-НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 84.8 хувьтай тайлагнагдсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 169,355.5 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал 6,123.3 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 6,256.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 5,049.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж, нийт батлагдсан төсөв 15.2 хувиар хэмнэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Ерөө сумын Бугант тосгоны 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 69.0 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал, 13.9 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,729,484.80	211,763,255.56
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		186,784,736.12
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө		0.00
31200	Банканд байгаа бэлэн мөнгө		186,784,736.12
31210	Төгрөг		186,784,736.12
31211	Төрийн сангийн харилцах		186,784,736.12
33	АВЛАГА		0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	28,729,484.80	24,978,519.44
35400	Хангамжийн материал	28,729,484.80	24,978,519.44
35470	Бусад хангамжийн материал	28,729,484.80	24,978,519.44
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	820,359,293.89	790,174,557.80
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	820,359,293.89	790,174,557.80
39200	Биет хөрөнгө	788,078,693.89	757,893,957.80
39201	Барилга, байгууламж, орон сууц	613,151,801.20	613,151,801.20
39202	Хуримтлагдсан элэгдэл	-76,599,962.64	-102,271,033.80
39203	Авто-тээврийн хэрэгсэл	14,562,500.00	14,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	0	-4,854,166.68
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	138,244,728.40	199,415,464.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	-33,459,625.63	-98,005,372.95
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	68,144,385.06	80,040,953.06
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,289,331.30	-35,244,528.73
39214	Бусад үндсэн хөрөнгө	13,873,900.00	13,873,900.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,409,667.65	-10,717,544.60
39216	Дуусаагүй барилга, байгууламж	53,843,324.00	53,843,324.00
39217	Ном	31,016,642.45	34,098,661.81
39300	Биет бус хөрөнгө	32,280,600.00	32,280,600.00
39303	Бусад биет бус хөрөнгө	32,280,600.00	32,280,600.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	849,088,778.69	1,001,937,813.36
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	849,088,778.69	1,001,937,813.36
51	Засгийн газрын хувь оролцоо	849,088,778.69	1,001,937,813.36
51100	Засгийн газрын оруулсан капитал	335,538,988.20	335,538,988.20
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		335,538,988.20
51200	Хуримтлагдсан үр дүн	-456,933,642.85	-304,084,608.18
51210	Өмнөх үеийн үр дүн	-531,820,333.64	-1,306,022,421.54
51220	Тайлант үеийн үр дүн	74,886,690.79	1,001,937,813.36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	970,483,433.34	970,483,433.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	849,088,778.69	1,001,937,813.36

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	890,565,104.86	2,120,568,229.71
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	650,602,500.00	1,035,399,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	650,602,500.00	1,035,399,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	97,729,015.66	856,192,217.34
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	11,529,289.20	35,906,909.25
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,085,800.00	2,923,101.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,052,800.00	2,823,101.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	548,000.00	100,000.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	7,985,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	500,000.00	
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	130,704,300.00	190,146,702.12
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	118,618,500.00	190,146,702.12
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,085,800.00	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	815,678,414.07	1,118,630,416.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,678,414.07	1,118,630,416.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	777,609,622.07	1,055,385,516.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,400,221.00	651,985,454.64
210101	Үндсэн цалин	309,596,010.00	486,382,604.64
210102	Нэмэгдэл	178,706,891.00	124,142,703.00
210104	Урамшуулал	29,097,320.00	21,175,747.00
210105	Гэрээт ажлын хөлс		20,284,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,328,796.00	82,386,710.24
210201	Тэтгэврийн даатгал	48,318,736.62	56,667,075.29
210202	Тэтгэмжийн даатгал	5,360,796.61	6,640,752.34
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,140,797.47	5,252,281.97
210204	Ажилгүйдлийн даатгал	955,314.90	1,256,817.36
210205	Эрүүл мэндийн даатгал	9,553,150.40	12,569,783.28
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,618,500.00	164,530,352.12
210301	Гэрэл, цахилгаан	4,943,500.00	8,027,043.12
210302	Түлш, халаалт	92,675,000.00	137,887,309.00
210303	Цэвэр, бохир ус	20,000,000.00	18,616,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,535,597.70	796,750.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,323,175.94	796,750.00
210401	Бичиг хэрэг	723,400.00	
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00	

**Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,442,500.00	
210404	Ном, хэвлэл	3,186,421.76	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,100.00	
2105	Нормативт зардал	3,135,600.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,375,100.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	760,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,370,400.00	
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	
210604	Урсгал засвар	3,370,400.00	
2107	Томилолт, зочны зардал	287,500.00	
210702	Дотоод албан томилолт	287,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	0.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,758,500.00	5,065,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,110,500.00	2,823,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	2,242,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	148,620,549.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	47,174,507.37	29,537,989.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,695,700.00	12,748,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,478,807.37	106,334,059.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,543,150.00	63,244,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,143,150.00	63,244,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,525,642.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	74,886,690.79	1,001,937,813.36
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	74,886,690.79	1,001,937,813.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/ төгрөгөөр /	
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	781,306,800.00	1,228,469,103.12	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,552,800.00	2,923,101.00	
120	Нийтлэг татварын бус орлого	3,552,800.00	2,923,101.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,552,800.00	2,923,101.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,052,800.00	2,823,101.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	100,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	659,135,500.00	1,225,546,002.12	
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	650,602,500.00	1,035,399,300.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	650,602,500.00	1,035,399,300.00	
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	7,985,000.00		
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	548,000.00		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	118,618,500.00	190,146,702.12	
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	118,618,500.00	190,146,702.12	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	778,038,100.00	1,001,367,967.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	778,038,100.00	1,001,367,967.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	731,080,673.50	938,123,067.00	
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	517,400,221.00	651,985,454.64	
210101	Үндсэн цалин	311,372,173.00	486,382,604.64	
210102	Нэмэгдэл	177,315,417.00	124,142,703.00	
210104	Урамшуулал	28,712,631.00	21,175,747.00	
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	20,284,400.00	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,299,587.00	82,386,710.24	
210201	Тэтгэврийн даатгал	48,289,527.62	56,667,075.29	
210202	Тэтгэмжийн даатгал	5,360,796.61	6,640,752.34	
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,140,797.47	5,252,281.97	
210204	Ажилгүйдлийн даатгал	955,314.90	1,256,817.36	
210205	Эрүүл мэндийн даатгал	9,553,150.40	12,569,783.28	
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,618,500.00	164,530,352.12	
210301	Гэрэл, цахилгаан	4,943,500.00	8,027,043.12	
210302	Түлш, халаалт	92,675,000.00	137,887,309.00	
210303	Цэвэр, бохир ус	20,000,000.00	18,616,000.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	6,356,200.00	796,750.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,645,000.00	796,750.00	
210401	Бичиг хэрэг	723,400.00		
210402	Тээвэр, шатахуун	1,200,000.00		
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,742,500.00		
210404	Ном, хэвлэл	385,200.00		

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	660,100.00	
2105	Нормативт зардал	1,498,600.00	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	738,100.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	760,500.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,470,400.00	2,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,100,000.00	
210604	Урсгал засвар	3,370,400.00	2,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	287,500.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,758,500.00	5,065,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,110,500.00	2,823,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	648,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	2,242,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,695,700.00	31,358,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	18,609,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,695,700.00	12,748,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,543,150.00	63,244,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,143,150.00	63,244,900.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.00	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,525,642.00	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,852,800.00	227,101,136.12
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	40,316,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	40,316,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	40,316,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	40,316,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	-40,316,400.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,852,800.00	186,784,736.12
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	186,784,736.12

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,538,988.20	970,835,534.54	-532,172,434.84	774,202,087.90
11	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	335,538,988.20	970,483,433.34	-456,933,642.85	849,088,778.69
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		0	352,101.20	352,101.20
15	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		-352,101.20	0	-352,101.20
19	Тайлант үеийн үр дүн			74,886,690.79	74,886,690.79
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	335,538,988.20	970,483,433.34	1,306,022,421.54	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	335,538,988.20	970,483,433.34	1,306,022,421.54	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,001,937,813.36	1,001,937,813.36
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	335,538,988.20	970,483,433.34	-304,084,608.18	1,001,937,813.36

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Харьцуулалт
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,228,469,103.12	1,041,684,367.00	186,784,736.12	84.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,228,469,103.12	1,001,367,967.00	227,101,136.12	81.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,159,100,903.12	938,123,067.00	220,977,836.12	80.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	803,313,900.00	651,985,454.64	151,328,445.36	81.2
210101	Үндсэн цалин	577,714,200.00	486,382,604.64	91,331,595.36	84.2
210102	Нэмэгдэл	186,123,900.00	124,142,703.00	61,981,197.00	66.7
210104	Урамшуулал	19,191,400.00	21,175,747.00	-1,984,347.00	110.3
210105	Гэрээт ажлын хөлс	20,284,400.00	20,284,400.00	0.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	100,413,801.00	82,386,710.24	18,027,090.76	82.0
210201	Тэтгэврийн даатгал	68,281,700.00	56,667,075.29	11,614,624.71	83.0
210202	Тэтгэмжийн даатгал	8,032,901.00	6,640,752.34	1,392,148.66	82.7
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,426,600.00	5,252,281.97	1,174,318.03	81.7
210204	Ажилгүйдлийн даатгал	1,606,400.00	1,256,817.36	349,582.64	78.2
210205	Эрүүл мэндийн даатгал	16,066,200.00	12,569,783.28	3,496,416.72	78.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	164,530,352.12	164,530,352.12	0.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	8,027,043.12	8,027,043.12	0.00	100.0
210302	Түлш, халаалт	137,887,309.00	137,887,309.00	0.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	18,616,000.00	18,616,000.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	796,750.00	796,750.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	796,750.00	796,750.00	0.00	100.0
2105	Нормативт зардал		0.00	0.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	0.00	0.00	0.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,322,100.00	5,065,700.00	6,256,400.00	44.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,823,100.00	2,823,100.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,499,000.00	2,242,600.00	6,256,400.00	26.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	76,724,000.00	71,674,500.00	5,049,500.00	93.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,975,500.00	58,926,000.00	5,049,500.00	92.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,748,500.00	12,748,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,368,200.00	63,244,900.00	6,123,300.00	91.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,368,200.00	63,244,900.00	6,123,300.00	91.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	69,368,200.00	63,244,900.00	6,123,300.00	91.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	0.00	0.00	
	Дотоод эх үүсвэрээс	0.00	0.00	0.00	

Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,228,469,103.12	1,228,469,103.12	0.00	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,035,399,300.00	1,035,399,300.00	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,035,399,300.00	1,035,399,300.00	0.00	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.00	0.00	0.00	
320001	Орон нутгийн төсвөөс	190,146,702.12	190,146,702.12	0.00	100.0
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,923,101.00	2,923,101.00	0.00	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,823,101.00	2,823,101.00	0.00	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	100,000.00	100,000.00	0.00	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	186,784,736.12	-	186,784,736.12
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	0.00	0.00	0.00	
620001	Удирдах ажилтан	0.00	0.00	0.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	0.00	0.00	0.00	
620003	Үйлчлэх ажилтан	0.00	0.00	0.00	
620004	Гэрээт ажилтан	0.00	0.00	0.00	0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь “Хүүхэд болон багшийн хөгжлийг дэмжин сургалтын чанарыг ахиулж, эерэг хандлагыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш бүр өөрийгөө хөгжүүлж, сургалтын арга зүйг оновчтой сонгон ур чадвараа дээшлүүлэхэд хамтран ажиллах,
- Хичээл сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулж сургалтын чанарыг ахиулах, цахим даалгаврын сан бүрдүүлэн ажиллах,
- Сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөн, арилгахад дэмжлэг үзүүлэн тэгш хамруулан сургах,
- Сурагчдын хөгжил төлөвшил, зөв хандлагыг хөгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулах,
- Сурагчдад эрүүл аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэхэд эцэг эхийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх,

3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагч болох БШУЯ-ны зүгээс дотоод аудит, хяналт, шалгалт хийгдээгүй бөгөөд дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус байгууллага нь өмнөх онуудад тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсны хувьд Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2020 оны А/202 тоот захирамжаар баталсан Сэлэнгэ аймгийн ТЕЗ-ийн харьяа төсөвт байгууллагууд дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг тайлант онд мөрдөж ирсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй өөрөөр хэлбэл боловсролын салбарын онцлогт тохирохгүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан

“Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 152,849.0 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		186,784.70	186,784.70
Бараа материал	28,729.50	24,978.5	(3,751.0)
Үндсэн хөрөнгө	820,359.30	790,174.60	(30,184.70)
Нийт хөрөнгө	849,088.80	1,001,937.8	152,849.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	849,088.80	1,001,937.8	152,849.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	849,088.80	1,001,937.8	152,849.0

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 186,784.7 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 24,978.5 мянган төгрөг болж 3,751.0 мянган төгрөгөөр буурсан нь БШУЯ-наас 1,532.1 мянган төгрөгийн түрээсийн ном, аймгийн БШУГ-аас 297.2 мянган төгрөгийн түрээсийн ном, 4,227.8 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн олон улсын байгууллагаас 1,120.3 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 87,501.2 мянган төгрөгийн бараа материал бэлтгэн, 98,429.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 76,149.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь БШУЯ-наас 3,082.1 мянган төгрөгийн сурах бичиг, 3,200.0 мянган төгрөгийн цахилгаан зуух, Дэлхийн Зөн олон улсын байгууллагаас 3,384.6 мянган төгрөгийн принтер, дижитал камер, Ерөө сумын ОНХС-ийн хөрөнгөөр 4,300.0 мянган төгрөгийн хоолны тогоо, Хан хэнтий тусгай хамгаалалтын газраас 21,866.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, төсвийн хөрөнгөөр 40,316.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авснаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,001,937.8 мянган төгрөг болж 152,849.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,046,061.8 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 175,925.0 мянган төгрөгөөр нийт зарлагыг **1,221,986.8** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

2022 оны 11 дүгээр сард хийсэн төсвийн зохицуулалтаар үйлчилгээний ажилчдын цалингийн зардалд 14,221.7 мянган төгрөгөөр төсвийг нэмж улсын төсвөөс 1,035,399.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 190,146.7 мянган төгрөг, түрээсийн номын орлого 2,823.1 мянган төгрөг, Ерөө сумын ЗДТГ-с 100.0 мянган төгрөг нийт **1,228,469.1** мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,035,399.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 190,146.7 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 100.0 мянган төгрөг, түрээсийн номын орлого 2,823.1 мянган төгрөг нийт **1,228,469.1** мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд захиран зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,041,684.4** мянган төгрөг буюу 84.8 хувьтай тайлагнагдсан нь цалин, НДШ-ын зардал 169,355.5 мянган төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардал 6,123.3 мянган төгрөгөөр, мэдээлэл технологийн үйлчилгээний зардал 6,256.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардал 5,049.5 мянган төгрөгөөр хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,399.60	3,399.60		100.0
		2	80312- Сургалт семинар	1,699.80	1,699.80		100.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,909.50	3,461.40	448.10	88.5
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	69,368.20	63,244.90	6,123.30	91.2
		5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	41,960.00	40,316.40	1,643.60	96.1

6	81823- Боловсролын багшийн сургалт	7,649.10	4,691.30	2,957.80	61.3
7	81834- Боловсролын стандарт сургалт	850,474.00	680,458.00	170,016.00	80.0
8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	56,939.10	51,343.20	5,595.90	90.2
9	81848-Сурах бичгийн түрээс	2,823.10	2,823.10		100.0
10	83602- Дээд шатны төсвөөс	100.00	100.00		100.0
11	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	166,530.40	166,530.40		100.0
12	80112-Нийтлэг үйлчилгээ	23,616.30	23,616.30		100.0
Нийт		1,228,469.10	1,041,684.40	186,784.70	84.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль гэх/ 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын аудитор Ц.Уртнасан, аудиторын туслах Т.Тунгалагтуяа нар гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбар-т 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 815,678.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 8,156.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад Төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Тайлант онд үдийн цайны зардал, бараа үйлчилгээний бусад зардал, орон дутуу ажилласнаас цалин, ажил олгогчоос төлөх НДШ зардлаас нийт 186,784.7 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Ерөө сумын Бугант тосгоны ерөнхий боловсролын сургууль нь мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“Бэйкер Тилли Далайван аудит” ХХК-ийн Дархан салбарын 2022 оны 11 дүгээр 09-ны өдрийн 40 дүгээр албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар дотоод журамд заасан хэмжээнээс илүү тооцон 325.0 мянган төгрөгийн шагналт цалин илүү олгосон зөрчил илэрч зөрчлийг арилгах төлбөрийн акт, шилэн дансны цахим хуудсанд 4 мэдээлэл дутуу илгээсэн, төлбөрийн цахим баримттай холбоотой 17,710.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгснөөс бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулалгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	325.0	1	325.0	100.0
Зөвлөмж	2	17,710.5	1	10,579.7	59.7
Нийт дүн	3	18,035.5	2	10,904.7	66.7

Өмнөх аудитаар өгсөн холбогдох хууль, тогтоомжийн дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлууд нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан, хяналт тавьж байх шаардлагатай байна.
2. Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан “Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан” гэсэн зориулалтаар, төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого / 120010 / ангиллаар гүйцэтгэхээр чиглэл хүргүүлсэн байна. Нэмэлтээр хуваарилах төсвийн эх үүсвэрийг төсвийн санхүүжилтийн эх үүсвэр болгон төлөвлөж байгаагаас гүйцэтгэлээр уг санхүүжилт хуваарилагдаагүй тохиолдолд төсвийн санхүүжилтийн төлөвлөгөө тасарснаар тайлагнагдах эрсдэлтэй байна. Иймд дээд шатны төсвөөс хуваарилах нэмэлт төсвийг төсвийн санхүүжилт хэлбэрээр урьдчилан төлөвлөж, батлалгүйгээр санхүүжилт ирсэн тухай бүр тухайн санхүүжилтийн дүнгээр зарцуулах эрх тавих нь зүйтэй юм.
3. Тус байгууллага нь өмнөх жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг байсан учир Сэлэнгэ аймгийн ЗД-ын 2020 оны 7 дугаар сарын 16-ний өдрийн А/202 дугаар захирамжаар баталсан “Сэлэнгэ аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж ирсэн байна. Бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч боловсролын байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй учир төсвийн ерөнхийлөн захирагчийн боловсруулсан НБББББ-ыг мөрдөх нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 125.5 мянган төгрөгийн үнэ бүхий Чингис хааны хөрөг зургийг шууд зардалд бүртгэсэн байсныг залруулав.

Аудитаар нийт **8,026.7** мянган төгрөгийн зөрчил илэрч 895.9 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 7,130.8 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр Э.Тамир, Б.Бүжинлхам нарт 212.7 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох

бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал, шийдвэргүйгээр олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Нягтлан бодогчийн тооцооллын алдаанаас ажилласан цагийн хөлсийг буруу тооцож Я.Янжиндулам, Б.Амангүл нарт 382.6 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

3. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авсан ажилчдад ажилласан хоногийг буруу тооцож 300.6 мянган төгрөгийн цалин илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.3 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд төлбөрийн цахим баримтаар баталгаажаагүй **7,130.8** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгийг шууд зардлаар бүртгэсэн	1	125.5			1	125.5	1	125.5				
Дүн	1	125.5			1	125.5	1	125.5				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тушаал шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон	1	212.7	1	212.7								
Илүү цагийн хөлс илүү олгосон	1	382.6	1	382.6								
Ажилласан хоног буруу тооцож илүү цалин олгосон	1	300.6	1	300.6								
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	7,130.8			1	7,130.8						
Дүн	4	8,026.7	3	895.9	1	7,130.8						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээллийг хугацаа хоцроосон								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								